



IX/2021


Тархаасан: 2021 оны 10 дугаар сарын 11



Үнэмлэхүй бага температур 2021 оны 9 дүгээр сард Завхан аймгийн Цэцэн-Уул суманд -17.6°C -д хүрсэн байна

Агаарын үнэмлэхүй их температур 2021 оны 9 дүгээр сард Баянхонгор аймгийн Шинэжинст суманд $+33.8^{\circ}\text{C}$, үнэмлэхүй бага температур Завхан аймгийн Цэцэн-Уул суманд -17.6°C -д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР ($^{\circ}\text{C}$), олон жилийн дундажтай¹ харьцуулснаар, станцын байршлаар, жил бүрийн 9 дүгээр сарын байдлаар



¹ - 1981-2010 он

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2021 оны 9 дүгээр сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр хэмжээ Хэнтий аймгийн Дадал суманд 110.5 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Баянхонгор аймгийн Шинэжинст суманд 29 м/с-д хүрсэн байна.

Агаарын чанар


Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн сарын хамгийн их агууламж 2021 оны 9 дүгээр сард 1-р хороолол, Зурагт, Амгалан орчимд 0.051 мг/м^3 - 0.066 мг/м^3 -д хүрч, агаарын чанарын хүлцэх агууламжаас 0.001 мг/м^3 - 0.016 мг/м^3 -аар давсан байна.

Азотын давхар ислийн сарын хамгийн их агууламж 2021 оны 9 дүгээр сард Хархорин зах, 32-ын тойрог, Баруун дөрвөн зам орчимд 0.058 мг/м^3 - 0.067 мг/м^3 -д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.008 мг/м^3 - 0.017 мг/м^3 -ээр давсан байна.

Харин PM 10 тоосонцрын сарын хамгийн их агууламж 2021 оны 9 дүгээр сард 32-ын тойрог, Хархорин зах орчимд 0.146 мг/м³ – 0.193 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.046 мг/м³ – 0.093 мг/м³-ээр давсан байна.

Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн дундаж агууламж 2021 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 0.004 мг/м³ (18.3%)-ээр, хүхэрлэг хийн дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.003 мг/м³ (29.8%)-ээр тус тус их байсан бол PM 2.5 тоосонцрын дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.006 мг/м³ (31.6%)-ээр, PM 10 тоосонцрын дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.024 мг/м³ (37.2%)-ээр тус тус бага байна.

ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 9 дүгээр сарын байдлаар, мг/м³



Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2021 оны эхний 9 сард 2857 болж, өмнөх оны мөн үеэс 270 (8.6%) -аар буурсан байна. Газар хөдлөлт 2021 оны эхний 9 сард 277 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 233 (6.3 дахин)-аар нэмэгдсэн байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 9 сарын байдлаар нийт 269 хүн амь насаа алдаж өмнөх оны мөн үеэс 61 (29.3%)-ээр нэмэгдсэн байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 9 сарын байдлаар 19.0 тэрбум төгрөгийн хохирол учирч, 1.1 тэрбум төгрөг зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 1. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ², жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-IX	2019 I-IX	2020 I-IX	2021 I-IX	<u>2021 I-IX</u> 2020 I-IX
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	тоо	3 186	3 896	3 127	2 857	91.7
Амь насаа алдсан хүн	тоо	170	171	208	269	129.3
Түлэгдсэн, бэртсэн, өвчилсөн хүн	тоо	51	84	65	618	9.5 ¹
Эвдэрсэн, сүйдсэн гэр, орон сууц, барилга	тоо	1 661	1 451	1 310	2 579	196.9
Объектын түймэр	тоо	2 742	3 274	2 315	1 847	79.8
Учирсан хохирол	тэрбум төгрөг	17.5	45.8	108.2	19.0	17.6
Зарцуулсан зардал	сая төгрөг	10 216.1	1 061.6	258.5	1 082.1	4.2 ¹

¹ - Дахин их

² - Корона вируст халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй.

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол

Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл

Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг

Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин

Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж

Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



Эх үүсвэр

Цаг уур, орчны шинжилгээний газар, Онцгой байдлын ерөнхий газар

Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь

2021 оны 11 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн
газрын дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын ахлах статистикч Б.Уянгаа
Утас : (976-51)-261563

